

## ДААТГАЛЫН МЭДЭЭ

2011 оны 4 дүгээр сар

### 1. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ:

2011 оны 4 дүгээр сарын байдлаар даатгалын салбарт үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон тусгай зөвшөөрөлд орсон өөрчлөлтүүд дараах байдалтай байна:  
/тоогоор/

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчид, өөрчлөлт	2011-3 сар	Нэмэгдсэн	Хасагдсан	2011-4 сар
1	Даатгалын компани	17			17
2	Даатгалын компанийн салбар	139	1 <sup>1</sup>		140
3	Даатгалын төлөөлөгч	1592			1592
4	Даатгалын зуучлагч	9			9
5	Даатгалын хохирол үнэлэгч	7			7
6	Актуарч	12			12
7	Бусад		3 <sup>2</sup>		

Тайлант үед даатгалын компани, даатгалын төлөөлөгч, даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч, актуарчийн тоонд өөрчлөлт ороогүй байна.

<sup>1</sup>Хорооны даргын 2011 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн 60 дугаар тушаалаар “Мөнх даатгал” ХХК-д Увс аймгийн Улаангом суманд даатгалын салбар нээн ажиллуулахыг зөвшөөрсөн;

<sup>2</sup>Хорооны 2011 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 110 дугаар тогтоолоор “Улаанбаатар хотын даатгал” ХХК-ийн ерөнхий нягтлан бодогчийн албан тушаалд Б.Мөнхчулууныг, 113 дугаар тогтоолоор “Тэнгэр даатгал” ХХК-ийн гүйцэтгэх захирлын албан тушаалд Г.Цогбадрахыг, 114 дүгээр тогтоолоор “Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр Д.Халиун, Д.Саранчимэг нарыг тус тус томилохыг зөвшөөрсөн.

### 2. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ:

Даатгалын байгууллагуудын 2011 оны 4 дүгээр сарын даатгалын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийг 2010 оны 4 дүгээр сарынхтай харьцуулбал:


#### Ердийн даатгалын компаниудын хувьд :

№	Үзүүлэлт	2010-4 сар	2011-4 сар
1	Даатгалын нийт хураамж	3,790,544,865.8	4,877,111,610.6
2	Олгосон нийт нөхөн төлбөр	551,294,283.9	642,082,553.4
3	Давхар даатгалд төлсөн хураамж	910,581,883.3	930,089,657.9
4	Байгуулсан даатгалын гэрээний тоо /ширхэг/	17,304	15,222
5	Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	180,394,500,000.0	27,537,979,471.0


6	Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	52,292,580.0	83,731,000.0
---	---------------------------------------	--------------	--------------

2011 оны 4 дүгээр сард даатгалын компаниудын байгуулсан даатгалын гэрээний тоо цөөрсөн боловч төвлөрүүлсэн даатгалын нийт хураамжийн орлого нь өмнөх оны мөн үеийнхээс 1,086.6 сая төгрөгөөр , урд сарынхаас 813.9 сая төгрөгөөр тус тус өсч, олгосон даатгалын нөхөн төлбөр өмнөх оны мөн үеийнхээс 90.8 сая төгрөгөөр өсч, урд сарынхаас 211.2 сая төгрөгөөр буурсан, давхар даатгалд төлсөн хураамж өмнөх оны мөн үеийнхээс 19.5 сая төгрөгөөр, урд сарынхаас 79.7 сая төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Даатгалын компаниудын олсон нийт даатгалын хураамж болон олгосон даатгалын нөхөн төлбөрийн өсөлт, бууралтыг 2011 оны эхний 4 сарын байдлаар дараах графикаар үзүүллээ /сая төгрөгөөр/:



Даатгалын компаниудын даатгалын хураамжийн орлого, нөхөн төлбөр, давхар даатгалд төлсөн хураамж /сая төгрөгөөр/




**Урт хугацааны даатгалын компанийн хувьд :**

№	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2010-4 сар	2011-4 сар
1	Даатгалын нийт хураамж	8,674,111.7	31,225,796.8
2	Олгосон нийт нөхөн төлбөр	2,735,090.0	6,008,084.0
3	Давхар даатгалд төлсөн хураамж		
4	Байгуулсан даатгалын гэрээний тоо	5	30
	Үүнээс: -Хувь хүний хугацаат даатгалд	5	12
	-Байгууллагын хугацаат даатгалд		2
	-Өндөр хамгаалалттай ЭМД-д		2
	-Эмнэлгийн мөнгөний даатгалд		6
	-Сургалтын төлбөрийн хуримтлалын даатгалд		5
	-Тэтгэврийн даатгалд		3
	-Орон сууцны даатгалд		
	-Хуримтлалын даатгалд		
	-Зээлдэгчийн амь насны даатгалд		
5	Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	616,500,000.0	30,000,000.0
6	Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	500,000.0	508,640.0

“Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн 2011 оны 4 дүгээр сарын даатгалын хураамжийн орлого болон нөхөн төлбөрийг 2010 оны мөн үеийнхтэй харьцуулбал даатгалын хураамжийн орлого 22.6 сая төгрөгөөр, даатгалын нөхөн төлбөр 3.3 сая төгрөгөөр тус тус өсч, өмнөх сарынхтай харьцуулахад даатгалын хураамжийн хэмжээ 17.6 сая төгрөгөөр өсч, даатгалын нөхөн төлбөр 4.5 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

“Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн олсон нийт даатгалын хураамж болон олгосон даатгалын нөхөн төлбөрийн өсөлт, бууралтыг 2011 оны эхний 4 сарын байдлаар дараах графикаар үзүүлээ /сая төгрөгөөр/:



**Даатгалын зуучлагч компаниудын хувьд :**

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2011-1 сар	2011-2 сар	2011-3 сар	2011-4 сар
1	Даатгуулагчаас шууд орж ирсэн даатгалын хураамж	17,536,876.2	12,278,487.7	67,806,527.4	33,494,569.7
2	Даатгалын зуучлагчийн орлого	13,180,745.4	12,488,198.0	26,375,510.9	11,945,725.9
3	Зуучилсан даатгалын гэрээний тоо	32	35	44	81
4	Зуучилсан даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	16,230,000,000.0	2,500,000,000.0	6,261,150,000.0	1,000,000,000.0

2011 оны 4 дүгээр сарын байдлаар даатгалын зуучлагч компаниуд 81 даатгалын гэрээг даатгагчдад зуучлан 11.9 сая төгрөгийн зуучлалын орлого олсон байна.

**Даатгалын хохирол үнэлэгч компаниудын хувьд :**

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2011-1 сар	2011-2 сар	2011-3 сар	2011-4 сар
1	Даатгалын хохирол үнэлсэний орлого	4,252,185.2	2,300,414.6	2,999,772.7	3,901,790.9
2	Үнэлсэн даатгалын хохирлын тоо	304	230	225	191
3	Үнэлсэн даатгалын хохирлоос хамгийн өндөр хохирлын дүн	28,870,000.0	24,074,000.0	33,160,000.0	69,407,178.0

2011 оны 4 дүгээр сарын байдлаар даатгалын хохирол үнэлэгч компаниуд 191 даатгалын тохиолдлын хохирлыг үнэлж, 3.9 сая төгрөгийн даатгалын хохирол үнэлсний орлоготой ажиллажээ.

**3. БУСАД**

Хорооны 2011 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн хуралдаанаар Даатгалын тухай хуулийн 55.2 дахь заалт, Хорооны 2010 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан “Тохиромжтой этгээдийг тодорхойлох заавар”-ын дагуу цаашид даатгалын компанийн эрх бүхий албан тушаалтныг компаниас нэр дэвшүүлсний дараа томилох шийдвэр гаргахаас нь өмнө Хорооны хуралдаанаар хэлэлцүүлж байх талаар даатгалын компаниудад мэдэгдэхээр шийдвэрлэсний дагуу 2011 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн 6/1434 тоот албан бичгээр нийт даатгалын компаниудад мэдэгдлийг хүргүүлсэн болно.